

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай
шүүгчийн захирамжийг хэвээр үлдээх тухай

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн давж заалдах журмаар хэргийг шийдвэрлэсэн

Шүүх бүрэлдэхүүн:

Шүүх хуралдаан даргалагч Ерөнхий шүүгч Б.Тунгалагсайхан

Бүрэлдэхүүнд оролцсон шүүгч Г.Билгүүн

Илтгэсэн шүүгч Н.Хонинхүү

Давж заалдах гомдол гаргасан хэргийн оролцогч:

Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Амгалан, А.Эрдэнэбилэг

Давж заалдах гомдол гаргасан шүүгчийн захирамж: 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай” 150 дугаар

Давж заалдах шатны шүүх хуралдааны оролцогчид:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Чимгээ

Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Амгалан

Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Т.Мөнхтуяа

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг. Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай” 150 дугаар захирамжаар:

1.1.“... Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.3-т заасныг тус тус баримтлан “Жавхлант орд” ХХК-ийн нэхэмжлэлтэй Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Засаг даргад холбогдох захиргааны хэргийг Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Гурвантэс сумын Цагдаагийн тасгийн мөрдөгчийн 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн “Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тухай” тогтоолтой, 222800369 дугаар эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлж” шийдвэрлэжээ.

Хоёр. Гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Амгалан, А.Эрдэнэбилэг нар дээрх захирамжийг эс зөвшөөрч 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргасан гомдолдоо:

2.1. "... Бүгд найрамдах хятад ард улсын хөрөнгө оруулалттай Жавхлант орд ХХК нь Монгол Улсын иргэн Л.Сүрэнхүүг хуурамч бичиг баримт үйлдсэн, 26 жилийн турш архивын баримтыг гэртээ хадгалж байсан гэж гомдол гаргасны төлөө хэргийн оролцогч бус Л.Сүрэнхүүд холбогдуулан нээсэн хэргийг үндэслэж хэргийг түдгэлзүүлсэнд гомдолтой байна. Жавхлант орд ХХК нь өвөлжөөний өмчлөгч Ч.Жамсран, Г.Цогтбаатар, өвөлжөөний 1500 м.кв газрыг эзэмшигч Б.Мөнхчимэг нарт нөхөн олговорт 300.000.000 төгрөг төлөхөөс зайлсхийхийн тулд цаг хугацаа авахын тулд Өмнөговь аймгийн Цагдаа, прокурорт нөлөөлж хэрэг үүсгүүлэн шүүхийн үйл ажиллагаанд саад учруулж байна. Төрөөс Ч.Жамсран, Г.Цогтбаатар нарт хувьчлан өгсөн өвөлжөөний бичиг баримт хуурамчаар үйлдэх хэрэгцээ шаардлага Л.Сүрэнхүүд огт байхгүй. Монгол Улсын иргэн өөрийн нутагтаа амьдрах аргагүй болж төрөөс иргэддээ хувьчилсан эд хөрөнгийг зөв буруу гэж ярих нь өмчлөгчийн хууль ёсны эрхэнд халдсан үйлдэл юм. Л.Сүрэнхүү нь хэргийн оролцогч бус этгээд гэдгийг шүүгч М.Цэцэгмаа мэдсээр байж хэргийг түдгэлзүүлсэн нь ойлгомжгүй, нэг талд үйлчилсэн мэт харагдаж байна. Иймд 150 дугаартай шүүгчийн захирамжийг хүчингүй болгож өгнө үү" гэжээ

ХЯНАВАЛ:

1. Анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж үндэслэл бүхий байх тул гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан гомдолд дурдсан үндэслэлээр захирамжийг хүчингүй болгох үндэслэлгүй байна.

2. Хэрэгт авагдсан баримтуудаас үзвэл гуравдагч этгээд Б.Мөнхчимэгээс "... 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Өмнөговь аймгийн Төрийн архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2021 оны ээлжит бус 02 дугаар хурлын тэмдэглэл, тус аймгийн Өмч хувьчлалын комиссын байна хадгалах хадгаламжийн нэгжийн үргэлжлэх бүртгэл, 1995 оны 10, 11, 12 дугаар сарын аж ахуйн нэгжийн баримт, хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, шаардах хуудас, хувьцаа эзэмшигчийн их хувьчлалын бичиг хүлээн авсан жагсаалт" зэрэг баримтуудын хавсаргаж, "Жавхлант орд" ХХК-ийн нэхэмжлэлтэй, Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Засаг даргад холбогдох захиргааны хэргийн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 281 дүгээр тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт гаргасан байх бөгөөд мөн шүүхийн шүүх хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 70 дугаар тогтоол¹-оор "Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 1 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 231 дүгээр магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 281 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болгож, гуравдагч этгээд Б.Мөнхчимэгийн хүсэлтийг хангаж" шийдвэрлэсэн байна.

2.2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Чимгээгээс "... шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах үндэслэл болсон шинээр гаргаж өгсөн баримтууд хуурамч байж болзошгүй тул Л.Сүрэнхүүд холбогдуулан ... Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар ... хуулийн дагуу шалгуулах гомдол, мэдээллийг Өмнөговь аймгийн Цагдаагийн газарт гаргасан, Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын Гурвантэс сумын Цагдаагийн тасгийн

¹ 2 дугаар хавтаст хэргийн 187-190 дүгээр хуудас

Мөрдөгчийн 2022 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тухай 222800369 дугаартай тогтоол²-оор уг гомдлыг шалгаж байгаа болох нь тогтоогдсон байна.

2.3. Иймээс анхан шатны шүүхийн "... 1995 оны 10, 11, 12 дугаар сарын баримт, Шаардах хуудас, Хувьцаа эзэмшигчийн их хувьчлалын бичиг хүлээн авсан жагсаалт зэрэг нотлох баримтуудыг хуурамч байж болзошгүй гэж үзэж уг баримтуудыг 26 жилийн турш хадгалж байсан гэх иргэн Л.Сүрэнхүүд холбогдуулан хэрэг үүсгэн, мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа болох нь тогтоогдсон, гуравдагч этгээдээс шүүхэд шинээр гаргасан дээрх баримтууд нь хэрэгт хамааралтай нотлох баримтууд байна ... дээрх нотлох баримтуудыг хуурамч байж болзошгүй гэж уг баримтуудыг хадгалж байсан гэх иргэн Л.Сүрэнхүүд холбогдуулан хэрэг үүсгэсэн нь тогтоогдсон" гэсэн үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.3-т "Эрүү, ... хэрэг хянан шийдвэрлэх, ... шийдвэрлэгдвэл зохих өөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс өмнө уг хэргийг хянан шийдвэрлэх боломжгүй" гэж заасантай нийцсэн байх тул шүүгчийн захирамжийг хэвээр үлдээх нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.6.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Өмнөговь дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай" 150 дугаар захирамжийг хэвээр үлдээж, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Амгалан, А.Эрдэнэбилэг нарын гомдлыг хангахгүй орхисугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.7 дахь хэсэгт зааснаар энэ тогтоол нь эцсийн шийдвэр болно.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Б.ТУНГАЛАГСАЙХАН

ШҮҮГЧ

Г.БИЛГҮҮН

ШҮҮГЧ

Н.ХОНИНХҮҮ

² 3 дугаар хавтаст хэргийн 104-105 дугаар хуудас